

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2023/153/НА- СТА-ТШЗ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	4
Аудитын гол асуудал .....	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1. Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	19

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.02.24 № 2/103

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г \_\_\_\_\_ Г

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН  
ДАРГА П.УРТНАСАН ТАНАА**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант онд 3,153.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 14,479.0 мянган төгрөгийн мод, 12,622.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг акталж устгахдаа байгууллагын дарга тушаал шийдвэр гаргаагүй, устгал хийсэн актыг үйлдээгүй;
- Санхүүгийн тайланд өөрийн орлогыг 8,610.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан;
- Санхүүгийн тайланд 594,846.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байхад жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 593,378.5 мянган төгрөгийн хөрөнгө тоологдож, 1,467.5 мянган төгрөгөөр зөрүүтэй, тооллогын комисс үндсэн хөрөнгө, бараа материалыг нэр төрлөөр нь тоолоогүй, нягтлан бодогч тооллогын дүнд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй;
- Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,370.0 мянга, хандив тусламжаар ирсэн 44,520.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд зөв бүртгээгүй;
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах албан шаардлага, бараа материалыг акталж

D/2023-A4 Alban toot.doc

005020407

устгахдаа байгууллагын дарга тушаал шийдвэр гаргаж, устгал хийсэн акт үйлдэж, анхан шатны баримтад хавсаргах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 2022 онд эдгээр зөрчил давтагдан гарсан;

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-73 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт УСНББОУС 17, УСНББОУС 19 болон Оршин байх, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2022 онд 71703 (Ойжуулалт) хөтөлбөрийн 9 арга хэмжээний зардалд 107,246.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 106,827.7 мянган төгрөгийг зарцуулж, 419.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, өөрийн орлогоор 8,000.0 мянган төгрөг оруулахаар батлагдсаныг бүрэн биелүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 115,457.3 мянган төгрөгийн тарьц, суулгац, 139,045.8 мянган төгрөгийн дунд оврын трактор, дагалдах хэрэгслийн хамт ирсэн байна.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллаагүйгээс 2022 онд зөрчил давтагдан гарсан нь байгууллагын удирдлага дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн, нягтлан бодогчийн ажлын хариуцлагатай холбоотой байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлгийн хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Баянхонгор аймгийн ЗДТГ-т тайлагнасныг тус газраас 81.8 хувиар үнэлсэн байна.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>272,203,267.88</u></b>	<b><u>448,506,072.88</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	114,129,692.88	94,567,692.88
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	114,129,692.88	94,567,692.88
3351	Байгууллагаас авах авлага	40,430,192.88	20,868,192.88
3352	Хувь хүмүүсээс авах авлага	73,699,500.00	73,699,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	158,073,575.00	353,938,380.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	158,073,575.00	353,938,380.00
35410	Бичиг хэргийн материал	470,100.00	926,600.00
35420	Аж ахуйн материал	8,648,775.00	8,057,400.00
35470	Бусад хангамжийн материал	148,954,700.00	344,954,380.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>340,328,728.45</u></b>	<b><u>505,295,149.39</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	340,328,728.45	505,295,149.39
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	268,197,928.45	433,164,349.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	50,401,200.00	91,391,450.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-6,855,420.92	-11,471,656.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	271,898,400.00	340,024,914.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-58,994,233.41	-62,171,525.55
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,744,453.00	35,259,486.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,373,470.22	-14,856,236.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,023,459.00	1,793,459.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,023,459.00	-695,959.02
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,377,000.00	54,779,933.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-889,515.56
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	72,130,800.00	72,130,800.00
39301	Программ хангамж	836,000.00	836,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-836,000.00	-836,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	72,130,800.00	72,130,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>612,531,996.33</u></b>	<b><u>953,801,222.27</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>200,014,000.00</u></b>	<b><u>200,799,500.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	200,014,000.00	200,799,500.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	200,014,000.00	200,799,500.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	785,500.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	200,014,000.00	200,014,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>412,517,996.33</u></b>	<b><u>753,001,722.27</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	412,517,996.33	753,001,722.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,388,886.00	211,388,886.00
51101	Өмч: - төрийн	211,388,886.00	211,388,886.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	200,741,110.33	541,612,836.27
51210	Өмнөх үеийн үр дүн	200,741,110.33	201,129,110.33
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	340,483,725.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	388,000.00	00.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>612,531,996.33</u></b>	<b><u>953,801,222.27</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,354,928,211.24</b>	<b>607,380,717.90</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>215,718,833.36</b>	<b>483,805,917.90</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	215,718,833.36	483,805,917.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	215,718,833.36	8,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	8,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	188,208,333.36	203,746,097.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	22,510,500.00	272,059,820.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,139,209,377.88</b>	<b>123,574,800.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,062,349,177.88	16,328,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,062,349,177.88	16,328,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	76,860,200.00	107,246,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,860,200.00	107,246,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,745,427,094.74</b>	<b>264,928,991.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,745,427,094.74</b>	<b>264,928,991.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,744,469,172.78	260,464,253.65
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	59,862,099.77	82,718,099.69
210101	Үндсэн цалин	57,222,099.77	79,614,499.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,640,000.00	3,103,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,149,518.25	10,754,600.00
210201	Тэтгэврийн даатгал	5,726,318.25	7,313,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	605,800.00	860,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	484,600.00	688,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	121,200.00	172,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,211,600.00	1,720,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	500,000.00	2,050,000.00
210301	Гэрэл, цахилгаан	500,000.00	2,050,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	54,476,460.00	34,174,775.00
210401	Бичиг хэрэг	587,900.00	843,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,499,000.00	2,896,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	131,980.00	180,000.00
210408	Бараа материал актасны зардал	48,257,580.00	30,255,275.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,986,000.00	684,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,988,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,998,000.00	684,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	500,000.00	1,250,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	1,250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,588,110,730.00	31,985,362.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,587,438,730.00	31,406,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	340,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	199,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	280,862.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	23,884,364.76	96,847,416.96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,020,000.00	58,665,740.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,864,364.76	38,181,676.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	957,921.96	4,464,738.31
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	4,045,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	4,045,600.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	457,921.96	419,138.31
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,921.96	419,138.31
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-390,498,883.50</b>	<b>342,451,725.94</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	1,968,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	1,968,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-1,968,000.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-390,498,883.50</b>	<b>340,483,725.94</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,188,293,877.88</b>	<b>161,679,292.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,000,000.00</b>	<b>8,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,000,000.00	8,000,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	5,000,000.00	8,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	8,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,183,293,877.88</b>	<b>153,679,292.88</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,106,433,677.88</b>	<b>46,432,492.88</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,106,433,677.88	46,432,492.88
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>76,860,200.00</b>	<b>107,246,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,860,200.00	107,246,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,188,293,922.88</b>	<b>160,309,292.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,188,293,922.88</b>	<b>160,309,292.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,187,336,000.92</b>	<b>145,302,061.69</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>60,141,298.60</b>	<b>81,932,599.69</b>
210101	Үндсэн цалин	57,501,298.60	78,828,999.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,640,000.00	3,103,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>8,159,979.44</b>	<b>10,754,600.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	5,736,779.44	7,313,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	605,800.00	860,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	484,600.00	688,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	121,200.00	172,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,211,600.00	1,720,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>500,000.00</b>	<b>2,050,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	500,000.00	2,050,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,679,000.00</b>	<b>4,376,000.00</b>
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	1,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,499,000.00	2,896,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	180,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,250,000.00</b>	<b>470,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,750,000.00	260,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	210,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>500,000.00</b>	<b>1,250,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	500,000.00	1,250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,107,105,722.88</b>	<b>53,011,354.88</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,106,433,722.88	52,432,492.88
210803	Даатгалын үйлчилгээ	340,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	199,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	280,862.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>957,921.96</b>	<b>4,464,738.31</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>500,000.00</b>	<b>4,045,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	4,045,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,038,664.84</b>	<b>10,961,631.19</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	457,921.96	419,138.31
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	21,580,742.88	10,542,492.88
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-45.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>1,370,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>1,370,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>1,370,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,370,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-1,370,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-45.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>45.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>211,388,886.00</b>	<b>388,000.00</b>	<b>591,236,663.78</b>	<b>803,013,549.78</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00		
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>211,388,886.00</b>	<b>388,000.00</b>	<b>591,236,663.78</b>	<b>803,013,549.78</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-390,495,553.45	-390,495,553.45
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>211,388,886.00</b>	<b>388,000.00</b>	<b>200,741,110.33</b>	<b>412,517,996.33</b>
D01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>211,388,886.00</b>	<b>388,000.00</b>	<b>200,741,110.33</b>	<b>412,517,996.33</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	388,000.00	388,000.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>211,388,886.00</b>	<b>388,000.00</b>	<b>201,129,110.33</b>	<b>412,905,996.33</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-388,000.00	00.00	-388,000.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	340,483,725.94	340,483,725.94
D09	<b>2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>211,388,886.00</b>	<b>00.00</b>	<b>541,612,836.27</b>	<b>753,001,722.27</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	115,246,800.00	114,827,661.69	419,138.31	99.6
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	115,246,800.00	114,827,661.69	419,138.31	99.6
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	111,201,200.00	110,782,061.69	419,138.31	99.6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	81,932,600.00	81,932,599.69	0.31	100.0
210101	Үндсэн цалин	78,829,000.00	78,828,999.69	0.31	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,103,600.00	3,103,600.00	-	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10,754,600.00	10,754,600.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	7,313,100.00	7,313,100.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	860,400.00	860,400.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	688,300.00	688,300.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	172,100.00	172,100.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	1,720,700.00	1,720,700.00	-	100.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,050,000.00	2,050,000.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	2,050,000.00	2,050,000.00	-	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,376,000.00	4,376,000.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	1,300,000.00	1,300,000.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	2,896,000.00	2,896,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	180,000.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,840,000.00	1,840,000.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,630,000.00	1,630,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	210,000.00	210,000.00	-	100.0

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,250,000.00	1,250,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	1,250,000.00	1,250,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,998,000.00	6,578,862.00	419,138.00	94.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00	6,000,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,000.00	199,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	99,000.00	-	100.0
210807	Газрын төлбөр	700,000.00	280,862.00	419,138.00	40.1
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2000000.00	2000000.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4045600.00	4045600.00	-	100.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,045,600.00	4,045,600.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,045,600.00	4,045,600.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	115,246,800.00	115,246,800.00	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	107,246,800.00	107,246,800.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	107,246,800.00	107,246,800.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	0	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	0	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	7	10	-3	142.9
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	0	0	0	-
620003	Үйлчлэх ажилтан	6	9	-3	150.0
620004	Гэрээт ажилтан	0	0	0	-
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>7</b>	<b>10</b>	<b>-3</b>	<b>142.9</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	10	-3	142.9
650010	Гэрээт ажилтан	0	0	0	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	46,432,492.88
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	46,432,492.88
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	46,432,492.88
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	46,432,492.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,432,492.88
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	46,432,492.88
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	46,432,492.88
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,432,492.88

### **3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги нь "Мод, тарьц, суулгацыг үржүүлж, аймгийн ногоон байгууламжид нийлүүлэх" эрхэм зорилготой тус байгууллага нь 10 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг дарга П.Уртнасан, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Нямхүү нар зурж, нярваар 2022.01.01-ний өдрөөс 2022.08.15-ны өдөр хүртэлх хугацаанд Ж.Анхцэцэг ажиллаж, 2022.12.19-ний өдрөөс ойжуулагч М.Мөнгөнцэцэгт нярвын ажлыг хариуцуулсан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Ойн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдсөн;
- Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчилснийг мөрдсөн;
- Засгийн газрын 2022 оны 107, 192 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн;
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 340,652.3 мянган төгрөгөөр буюу 55.6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт А	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	
Авлага	114,129.70	94,567.70	19,562.00
Бараа материал	158,073.60	353,938.40	(195,864.80)
Үндсэн хөрөнгө	340,328.70	504,678.10	(164,349.40)
Нийт хөрөнгө	612,531.90	953,184.20	(340,652.30)
Өр төлбөр	200,014.00	200,799.50	(785.50)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	412,517.90	752,384.70	(339,866.80)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	612,531.90	953,184.20	(340,652.30)

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2021 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Оны эхний авлагаас 30,104.5 мянган төгрөгийн авлага барагдсанаас 21,580.7 мянган төгрөгийн авлага нь орон нутагт төвлөрүүлсэн санхүүжилтийн авлага байсан бөгөөд 2021 онд борлуулсан өвс, тэжээл борлуулснаас үүссэн авлагаас Гурванбулаг сум авлагыг бүрэн барагдуулж, бусад сумд авлагыг бүрэн барагдуулаагүй байна. Санхүүгийн тайланд бүртгэлтэй авлагын 77.9 хувь буюу 73,699.5 мянган төгрөгийн авлага нь "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-ын 2017-2020 онд үүссэн иргэн, сумдад олгосон өвс, тэжээлийн авлага байгаа ба тус авлага барагдаагүй байна.

Хүснэгт 2. Авлагын судалгаа (мянган төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Барагдсан	Эцсийн үлдэгдэл
1	"Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ	73,699.50	-	-	73,699.50
2	Бууцагаан сум	4,388.50	-	-	4,388.50
3	Баацагаан сум	1,650.00	-	-	1,650.00
4	Баян-Өндөр сум	1,172.20	-	-	1,172.20
5	Баянцагаан сум	11,356.25	-	8,241.25	3,115.00
6	Гурванбулаг сум	282.50	-	282.50	-
7	Оны эцэст төвлөрүүлсэн орлогын авлага	21,580.74	10,542.49	21,580.74	10,542.49
	Дүн	114,129.69	10,542.49	30,104.49	94,567.69

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн ерөнхий дэвтэр

Баянхонгор аймгийн ЗДТГ-аас тендер зарлаж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймгийн Түмэн мод цөлжилттэй тэмцэх ногоон байгууламжийн багц 1 ажлыг гүйцэтгэх гэрээг Баянхонгор аймгийн Засаг дарга, “Чандмань хархираа” ХХК-ийн захиралтай 2022.03.25-ны өдөр байгуулж, 115,457.3 мянган төгрөгийн үнэ бүхий 3 нэр төрлийн 2,000 ширхэг модны тарьц суулгац, 55,000 ширхэг харандаан суулгац, 606 кг модны үр нийлүүлэхээр гэрээ байгуулж, 2022.05.02-ны өдөр хүлээлгэн өгсөн нь бараа материалын дүн өсөхөд голлох нөлөө үзүүлжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022.08.30-ны өдрийн А/372 дугаар тушаалаар 139,045.8 мянган төгрөгийн бага оврын трактор, дагалдах хэрэгсэл хандиваар ирсэн, өмнөх онд хандив тусламжаар баригдаж, 2022 онд ашиглалтад хүлээн авсан 40,990.3 мянган төгрөгийн конторын барилгыг бүртгэснээр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын тогтоолоор 2022.09.16-ны өдрийн 10/42, 10/43, 10/46 дугаар тогтоолуудаар 25,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий УАЗ-22069 маркийн суудлын автомашиныг акталж, дуудлага худалдаагаар аймгийн Орон нутгийн өмчийн газар борлуулсан, 1,398.4 мянган төгрөгийн хайсыг Богд сумын ЗДТГ-т шилжүүлж, ашиглалтын хугацаа дууссан 4,343.4 мянган төгрөгийн 9 үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 339,866.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 540,995.8 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар шилжүүлсэн хайсны 388.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний зөрүү буурснаар тус дүнгээр өмнөх үеийн үр дүн буурч, тайлант үеийн үр дүн 339,866.7 мянган төгрөгөөр нэмэгдэн цэвэр хөрөнгийн дүн 752,384.7 мянган төгрөг болсон байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 158,050.2 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөс санхүүжих зардлыг 72,299.0 мянган төгрөгөөр хасаж, 85,751.2 мянган төгрөгөөр баталсан нь цалин, нормын хувцас, зөөлөн эдлэл авах зардал, урсгал засварын болон бараа үйлчилгээний бусад зардлуудыг хасаж баталсантай холбоотой байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги аймгийн хэмжээнд 20 сая мод тарих гэрээг байгуулсны дагуу 2022.02.14-ний өдөр 10 тоот албан бичгийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлж орон тоог 7-оос 12 болтол нэмэгдүүлэх хүсэлт явуулсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2022.05.25-ны өдрийн 9/24 дүгээр тогтоолоор анхны батлагдсан төсвийг 25,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон тоог 3-аар нэмсэн гэх боловч орон тоог нэмсэн талаар албажуулсан шийдвэр байхгүй, орон тоог

төсвийн төлөвлөлтийн программд нэмж оруулаагүй 7 хэвээр байна. Иймд тус асуудлыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх аудитын багт танилцуулж, аудитын тайланд тусгахаар шийдвэрлэв.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022.08.30-ны өдрийн А/372 дугаар тушаалаар 139,045.8 мянган төгрөгийн бага оврын трактор, дагалдах хэрэгсэл хандиваар өгч, Улаанбаатар хотоос Баянхонгор аймагт тракторыг тээвэрлэх зардалд орон нутгийн төсвөөс 4,000.0 мянган төгрөгийг олгохоор шийдвэрлэж, нийт төсвийг 115,246.8 мянган төгрөгөөр баталж, үүнээс 8,000.0 мянган төгрөгийг өөрийн орлогоор санхүүжүүлэхээр заажээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71703 (Ойжуулалт) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс баталсан 107,246.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, гүйцэтгэлээр 106,827.7 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийн 419.1 мянган төгрөгийг оны эцэст төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	81,932.60	81,932.60	0.00	100.0
2	Ажил олгогчоос төлөх НДШ	10,754.60	10,754.60	0.00	100.0
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,050.00	2,050.00	0.00	100.0
4	Хангамж бараа материалын зардал	4,376.00	4,376.00	0.00	100.0
5	Эд хогшил, урсгал засварын зардал	1,840.00	1,840.00	0.00	100.0
6	Томилолт, зочны зардал	1,250.00	1,250.00	0.00	100.0
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,998.00	6,578.80	419.20	94.0
8	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.00	2,000.00	0.00	100.0
9	Урсгал шилжүүлэг	4,045.60	4,464.70	-419.1	110.3
ДҮН		115,246.80	115,246.70	0.10	99.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар өмнөх оны санхүүжилтийн болон өвсний авлага, худалдан борлуулсан өвс, модны үнэ, трактор ажиллуулсны хөлс зэрэг нийт 46,432.5 мянган төгрөгийн орлого орж, зарцуулаагүй үлдэгдлийг орон нутагт төвлөрүүлснээр санхүүгийн тайланд 10,542.3 мянган төгрөгийн авлага нэмэгдсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитаар тооллогыг хийхдээ үндсэн хөрөнгө, бараа материалын нэр төрлөөр тоолж, тооллогын дүнд үндэслэн нягтлан бодогч тооцоо бодож байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022.12.09-ны өдрийн 73 дугаар албан бичгээр ирүүлж, санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 115,246.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,728.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,210.1 мянган төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэн ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,

нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 110,824.4 мянган төгрөгийн 10 гүйлгээ, зарлагын 21,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 16,629.3 мянган төгрөгийн 5 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,000.0 мянган төгрөгийн 1 орлогын, 6,790.0 мянган төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 59,020.0 мянган төгрөгийн 4 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг дутуу байршуулсан зөрчил өмнөх онд илэрч, албан шаардлага өгсөн байхад хэрэгжүүлээгүйгээс 2022 онд зөрчил давтан илэрсэн тул төсвийн захирагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, 435,129.2 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илрүүлэн, санхүүгийн тайланд 290,579.5 мянган төгрөгийн 3 залруулга хийж, 2,925.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 91,500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, менежментийн захидлаар 50,124.7 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Өмнөх оны аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага, “Холбогдох шийдвэрээр хөрөнгө актлахдаа комисс томилж, хөрөнгийг устгал хийсэн акт үйлдэж, анхан шатны баримтад хавсаргаж байх” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн тайлангаар зөрчил давтагдан гарч, өмнөх оны шийдвэрийн дундаж биелэлт 81.3 хувьтай байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,925.00	1	2,925.00	100.0
Албан шаардлага	1	91,500.00	1	91,500.00	50.0
Зөвлөмж	4	50,124.70	4	50,124.70	75.0
Залруулга	3	290,579.50	3	290,579.50	100.0
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>435,129.20</b>	<b>9</b>	<b>435,129.20</b>	<b>81.3</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022.05.25-ны өдрийн 46 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2022.05.25-ны өдөр 46 дугаар албан бичгээр ирүүлсэн, төлбөрийн актыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харин шилэн дансны цахим хуудаст мэдээллийг байршуулах, хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй, өмнөх жил гарсан зөрчил давтагдсан байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

"Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-ын 2017-2020 онд үүссэн иргэн, сумдад олгосон өвс, тэжээлийн авлага байгаа ба тус авлага барагдаагүй байгаа тул цаашид хууль, хяналтын байгууллагаар тус асуудлыг шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

"Чандмань хархираа" ХХК-аас хандивласан 180 ширхэг нохойн хошууны суулгац, Баянлиг сумаас бэлдсэн 12,000 ширхэг сухайны тайраадас зэргийг мод үржүүлгийн талбайд тарьсан гэх боловч санхүүгийн тайланд үнэлж бүртгээгүй байгааг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй байна.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 54,501.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг залруулав. Үүнд:

1. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 670.0 мянган төгрөгийн принтер, 700.0 мянган төгрөгийн угтвар ширээг аж ахуйн материалд бүртгэсэн;
2. Санхүүгийн тайланд өөрийн орлогыг 8,610.5 мянган төгрөгөөр дутуу тусгасан;
3. Тайлант онд хандиваар ирсэн 44,520.9 мянган төгрөгийн 4 нэр төрлийн тоног төхөөрөмжийг барилга байгууламж дансанд бүртгэсэн байна.

Аудитаар нийт 42,048.5 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 10,325.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 30,255.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,467.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг менежментийн захидлаар өгсөн.

#### **5.1. Төлбөрийн акт**

1. Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 2021 онд үүссэн Баацагаан сумын 1,650.0 мянга, Бууцагаан сумын 4,388.5 мянга, Баян-Өндөр сумын 1,172.2 мянга, Баянцагаан сумын 3,115.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн авлагын нийт 10,325.7 мянган төгрөгийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэснийг зөрчсөн тул сумдаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

1. Тайлант онд 3,153.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, 14,479.0 мянган төгрөгийн мод, 12,622.9 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг акталж устгахдаа байгууллагын дарга тушаал шийдвэр гаргаагүй, устгал хийсэн акт үйлдээгүй, өмнөх он тус зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70-73 дугаар зүйлийг зөрчсөн байгаа тул холбогдох шийдвэрийг гаргаж, устгалын актыг үйлдэж, анхан шатны баримтад хавсаргах зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,000.0 мянган төгрөгийн орлогын 1, 6,790.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, 59,020.0 мянган төгрөгийн 4 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” 6.4.8 дахь “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэснийг зөрчсөн тул орхигдуулсан мэдээллийг байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нөхөн мэдээлэх албан шаардлагыг өгөв.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд 594,846.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байхад жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 593,378.5 мянган төгрөгийн хөрөнгө тоологдож, 1,467.5 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь тооллогын комисс нийт үнийн дүн буруу гаргасантай холбоотой ба тооллогын комисс үндсэн хөрөнгө, бараа материалыг нэр төрлөөр нь тоолоогүй, нягтлан бодогч тооллогын дүнд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж

дансны үлдэгдлийг тулган шалгана” гэснийг хэрэгжүүлж ажиллах, тооллогыг үндсэн хөрөнгө, бараа материалын нэр төрлөөр тоолж, үнэн зөв тайлагнаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 670.000 төгрөгийн принтер, 700.000 төгрөгийн угтвар ширээг аж ахуйн материалд бүртгэсэн байна.	1	1,370.0					1	1,370.0				
Санхүүгийн тайланд өөрийн орлогыг 8,610,500 төгрөгөөр дутуу тусгасан.	1	8,610.5					1	8,610.5				
Тайлант онд хандиваар ирсэн 44,520,900 төгрөгийн 4 нэр төрлийн тоног төхөөрөмжийг барилга байгууламж дансанд бүртгэсэн байна.	1	44,520.9					1	44,520.9				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>54,501.4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>54,501.4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
2021 онд үүссэн санхүүгийн тайланд бүртгэлтэй Баацагаан, Бууцагаан, Баян-Өндөр, Баянцагаан сумдаас авах өвс тэжээлийн авлагын 10,325,700 төгрөгийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	10,325.7	1	10,325.7								

Тайлант онд 30,255.3 мянган төгрөгийн бараа материалыг акталж устгахдаа байгууллагын дарга тушаал шийдвэр гаргаагүй, устгал хийсэн акт үйлдээгүй, өмнөх он тус зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	30,255.3			1	30255.3							
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 2022 онд зөрчил дахин илэрсэн байна.	1	-							1	0			
Санхүүгийн тайланд 594,846,000 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байхад жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 593,378,500 төгрөгийн хөрөнгө тоологдож, 1,467,500 төгрөгөөр зөрүүтэй, тооллогын комисс үндсэн хөрөнгө, бараа материалыг нэр төрлөөр нь тоолоогүй, нягтлан бодогч тооллогын дүнд үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй байна.	1	1,467.5				1	1,467.5						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>42,048.5</b>	<b>1</b>	<b>10,325.7</b>	<b>1</b>	<b>30,255.3</b>	<b>1</b>	<b>1,467.5</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5,000.0 мянган төгрөгийн орлогын 1, 6,790.0 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээ, 59,020.0 мянган төгрөгийн 4 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан байна.	1	0	0	0	1	0	0	0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

---oOo---